

АМЬДРАЛЫН ДААТГАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Доктор (Ph.D) Б. Нацагдорж^{1,а}

¹Мандах их сургуулийн Эдийн засаг, бизнесийн тэнхимийн багш

^аЦахим хаяг

Хураангуй

Амьдралын даатгал нь хүмүүс өөрсдийн амьдралын баталгаат эх үүсвэрийг хангахын тулд хийдэг хамгаалалт бөгөөд амь насны, гэнэтийн ослын, эрүүл мэндийн, тэтгэврийн, хуримтлалын зэрэг хүний амьдрал, амьжиргаагаар холбоотой даатгалын үйлчилгээ үзүүлдгээрээ бусад даатгалаас ялгаатай юм. Амьдралын даатгал нь өөртөө болон гэр бүлдээ санхүүгийн хамгаалалт үүсгэхийн зэрэгцээ нийгмийн хамгаалал дээр нэмэлт баталгаа болж, төрийн ачааг хөнгөлөх ач холбогдолтой. Дэлхийн даатгалын зах зээлийн нийт хураамжийн орлогын 54.3 хувийг амьдралын даатгалын хураамж эзэлж байна. Тайван, Итали, Япон, Англи, Франц зэрэг хөгжингүй орнуудад нийт даатгалын дүнд эзлэх амьдралын даатгалын хувийн жин өндөр байна. Монгол Улсад амьдралын даатгалын “National Life” гэх ганц компани үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Тус компани одоогоор даатгалын нийт хураамжийн ердөө ганц хувийг л бүрдүүлж байгаа юм.

Түлхүүр үг: амьдралын ба амьдралын бус, хураамж, даатгалын гүнзгийрэлт, даатгалын нягтрал

1. АМЬДРАЛЫН ДААТГАЛЫН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

Хүмүүсийн амь нас, эрүүл мэнд эрсэдсэнээс үүдэн гарах хохирлыг барагдуулах мөнгөн хөрөнгө бий болгож байсан тухай мэдээлэл хүн төрөлхтний түүхийн эрт үеэс тэмдэглэгджээ. Амьдралын даатгалын үзэгдэл эрт дээр үед ч байсан ба хүмүүс өөрийн оршуулгын зардалдаа зориулж мөнгө хадгалдаг байснаас үүдэлтэй. Эртний Ромын түүхэнд тэмдэглэгдсэнээр амьдралын даатгалын анхны хэлбэр болох “Оршуулгын клубууд” /burial clubs/ нь гишүүдийнхээ оршуулгын зардал болон амьд үлдсэн хүмүүст нь үзүүлэх санхүүгийн тусламжийн зардалд зориулсан хамгаалалттай байжээ. Европод 17-18 - р зууны зааг дээр амьдралын даатгалыг далайн тээврийн даатгалд нэмэлт болгон бие даасан бизнес хэлбэрээр үүсгэн байгуулжээ. Өөрөөр хэлбэл, далайн хөлөг онгоц болон ачаа барааг даатгахын хажуугаар хөлөг онгоцны ахмадын амь насыг урт хугацаагаар даатгадаг байжээ. Ийнхүү эрдэнэт хүний амь насыг ачаа бараанаас илүүгээр үнэлж, түүгээр ч барахгүй, олон жилээр, урт хугацаанд даатгадаг болсноор даатгалын тогтолцооны хөгжилд чанарын нэг алхам хийгдэж, амьдралын даатгал үүссэн түүхтэй юм.

1663 онд Жеймс Додсон гэдэг хүн Лондонгийн бүх оршуулгын газрын мэдээллийн үндсэн дээр нас барагсдын дундаж нас болоод жилд нас бардаг тохиолдлын тоог тогтоож, уг статистик мэдээллээ амьдралын даатгалын хураамжийн тооцоололд ашиглажээ. Даатгалын түүхэнд Жеймс Додсонг амьдралын даатгалд шинжлэх ухааны үндэслэлийг анх оруулсан хүнд зүй ёсоор тооцдог юм. Цаашид магадлалын онол хөгжиж, амьдралын даатгалын тооцоололтой Францын алдарт математикч Блез Паскаль, Пьер Ферма нарын нэр ч холбогддог. Дэлхийн анхны амьдралын даатгалын компанийг 1740 онд “Сайхан амьдралын нийгэмлэг”-ийг байгуулсан бол дараагаар 1762 онд “Шударга амьдралын даатгалын нийгэмлэг” (Equitable Life Assurance Society) нэртэй даатгалын компани Лондонд үүсэн байгуулагдаж, өнөөг хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна. 19 дүгээр зууны сүүл, 20 дугаар зууны эхэн үед эдийн засгийн хөгжилтэй орнуудад төрийн зүгээс ажилчдыг даатгалтай болгоход их анхаарал тавьж хувийн даатгалын төрлүүд болох гэнэтийн ослын улмаас нас барах, хөдөлмөрийн чадвараа түр алдах, тэжээгчээ алдах даатгалын зэрэгцээ ажилгүйдлийн даатгал бий болсон.

2. АМЬДРАЛЫН ДААТГАЛЫН ОНОЛЫН АСУУДАЛ

Амьдралын даатгал нь хүний амь нас, эрүүл мэндэд эрсдэл тохиолдсон үед даатгуулагчынхаа орлогыг тасалдалгүй үргэлжлүүлэх, улмаар тэдний гэр бүлийн санхүүгийн тогтвортой байдлыг баталгаажуулах үүрэгтэй байдаг. Мөн хувь хүн болоод нийгмийн өмнөө тавьсан зорилгод хүрэхэд шаардлагатай мөнгөн хуримтлалыг бий болгох хөрөнгө оруулалтын хэрэгсэл болдог юм. Амьдралын даатгал нь ердийн даатгалтай харьцуулахад дараах онцлог ялгаатай байдаг. Үүнд: 1. Урт хугацаатай 2. Даатгалын объект нь зөвхөн хүний амь нас, эрүүл мэнд, амьдрах баталгаат байдалтай холбоотой зүйл болдог ба үүнд: нэмэлт тэтгэвэр, тэтгэврийн даатгалын өв залгамжлал, эрүүл мэндийн даатгалын онцгой төрлүүд, хуримтлал зэргийг ойлгоно. 3. Ирээдүйд тохиолдох тодорхой эрсдэлийг /нас баралт, хөдөлмөрийн чадвар алдалт г.м./ даатгадаг.

Амьдралын даатгал ба ердийн даатгалын бас нэг том ялгаа нь амьдралын даатгалын тохиолдол нь тухайн хүний хүсэл эрмэлзлээс үл хамааран амьдралд хэзээ нэгэн цагт заавал бий болдог бол ердийн даатгалын тохиолдол нь ерөөсөө хэзээ ч бий болохгүй байх нь магадлалтай байдагт оршино. Жишээ нь: хүн хөгширнө, өвчинд нэрвэгдэнэ, бас үхнэ. Ийм л ялгаатай учраас хүн төрөлхтөн өдий болтол даатгалыг амьдралын даатгал, амьдралын бус даатгал гэж ангилаад хүнийг нь амьдралын даатгалд, эд баялгийг нь ердийн даатгалд

хамруулдаг болсон юм. Амьдралын даатгалын зорилгыг нийгмийн болоод санхүүгийн гэж 2 ангилж авч үзэж болно.

1. Нийгмийн зорилго: Төрийн нийгмийн хамгааллын дутууг нөхөхөд чиглэгдэж байдаг.
2. Санхүүгийн зорилго: Даатгуулагчийн бодит орлогыг нэмэгдүүлэх, санхүү зээлийн үйл ажиллагаа явуулах шаардлагатай баталгааг нь олгодог.

Амьдралын даатгалын гэрээнүүдийг үндсэн гурван төрөлд ангилна. Үүнд:

1. Амьдралын хугацаат даатгал

Даатгуулагч зөвхөн даатгалтай хугацаанд нас барсан тохиолдолд даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал.

2. Насан туршийн амьдралын даатгал

Энэ нь бүх амьдралын туршид хийгдэх даатгал бөгөөд даатгуулагч ямарч хугацаанд нас барсан гэр бүлд нь нөхөн олговор олгох нөхцөлтэй байна.

3. Амьдралын холимог даатгал

Даатгуулагч гэрээний хугацааны эцэст амьд байсан тохиолдолд өөрт нь, гэрээний хугацаа дуусахаас өмнө нас барсан тохиолдолд гэр бүлд нь мөнгөн төлбөр төлнө. Эдгээр үндсэн төрлүүд нь хуримтлалын, тэтгэврийн, эрүүл мэндийн, аннуити гэх мэт маш олон хэлбэрийн даатгалын гэрээ болон хуваагддаг. Амьдралын даатгал нь үр хүүхдийнхээ ирээдүйн боловсролд хөрөнгө оруулалт хийх, орон сууц, үл хөдлөх хөрөнгө худалдан авах, тэтгэвэрт гарсан үедээ санхүүгийн хувьд хэн нэгнээс хараат бус амьдрах нэмэгдэл тэтгэврийн эх үүсвэртэй болох гэх мэт амьдрал амьжиргаанд шаардагдах мөнгөн хуримтлалыг бий болгохын зэрэгцээ өвдсөн, осол гэмтэлд өртсөн тохиолдолд санхүүгийн дэмжлэг авах, эмчилгээ, оношлогоо өндөр хөгжсөн улс орнуудад санхүү мөнгөний бэрхшээлгүйгээр эмчлүүлэх боломжийг олгодог. Амьдралын даатгалыг хөгжүүлснээр нийгмийн хамгаалал нь зөвхөн төрийн үүрэг гэсэн туйлшралаас ард иргэдийг салгах, хувь хүн өөрийнхөө ирээдүйн төлөө санаа тавьдаг болох, иргэд төрийн гар харахгүйгээр даатгалаар дамжуулан ирээдүйгээ өөрсдийн гарт авдаг сэтгэлгээтэй болох, төрийн дэмжлэгээс хамааралтай хүмүүсийн тоо цөөрснөөр нийгмийн халамжийн зардал буурч, төрийн нуруун дахь ачаалал багасах, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэ эх үүсвэртэй болох, үнэт цаасны зах зээлийн хөгжлийг хурдасгах зэрэг олон чухал ач холбогдолтой юм.

3. ОЛОН УЛСЫН АМЬДРАЛЫН ДААТГАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Дэлхийн өндөр хөгжилтэй улс оронд амьдралын даатгал нь хувь хүний санхүүгийн төлөвлөлтийн найдвартай хэрэгсэл, тухайн улс орныхоо санхүүгийн зах зээлийн томоохон бүрэлдэхүүн хэсэг болдог байна. Амьдралын даатгал нь даатгуулсан иргэдэд ашигтайгаас гадна нийгэмд өөр олон олон хэлбэрээр үр өгөөжөө өгнө. Тухайлбал, амьдралын даатгалын нөөц сангуудыг орон сууцны урт хугацааны зээлийн эсвэл дэд бүтцийг барьж байгуулах ажлын санхүүжүүлэх эх үүсвэрт ашиглана. Мөн түүнчлэн Засгийн газрын урт, богино хугацааны үнэт цаасыг худалдан авахад эх үүсвэр болгодог аж. Өөрөөр хэлбэл амьдралын даатгал нь нийгэмд нэгэнт бий болгосон орлогыг хэрэглээнд биш харин хуримтлал болгон нийгмийн өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд хамгийн тохиромжтой, хамгийн гол нь оролцогч бүх талуудад ашигтай санхүүгийн хэрэгсэл юм. Дэлхийн даатгалын зах зээл нь амьдралын /life insurance/ ба амьдралын бус /non life insurance/ гэсэн чиглэлээр хөгжиж байгаа бөгөөд даатгалын зах зээлийн нийт хураамжид амьдралын даатгалын хураамжийн эзлэх хувийг авч үзье.

Хүснэгт 1. Дэлхийн даатгалын зах зээлийн нийт хураамжийн орлого. 2016 - 2017 он

/сая ам. доллар/

Жил	Амьдралын даатгал	Амьдралын бус даатгал	Нийт
2016	\$ 2,581,972	\$ 2,120,869	\$4,702,841
2017	2,657,270	2,234,424	4,891,694

Эх сурвалж: Swiss Re, sigma database, sigma 3/2018

Хүснэгт 1-ээс харахад дэлхийн даатгалын зах зээлийн нийт хураамжийн орлогын 54,3 хувийг амьдралын даатгалын хураамжийн орлого эзэлж байна. Энэ нь амьдралын даатгал нь хэдийгээр ердийн даатгалаасаа хожуу үүссэн боловч хөгжил нь илүү хурдацтай явж байгаагийн илрэл юм. Дэлхийн даатгалын зах зээлийн 28.1 хувийг АНУ ганцаараа бүрдүүлдэг бөгөөд нийт зах зээлийн 74,8 хувийг бүрдүүлж байгаа 10 орны амьдралын даатгалтай холбоотой зарим үзүүлэлтийг авч үзье. Амьдралын даатгалын хэрэглээг олон улсад гүнзгийрэлтийн түвшин болон нягтралын харьцаагаа тооцдог. Гүнзгийрэлтийн түвшинг хураамжийн орлогыг ДНБ, харин нягтралын түвшинг хураамжийн орлогыг нийт хүн амын тоонд харьцуулан тооцдог.

Хүснэгт 2. Дэлхийд даатгалын хураамжийн орлогоор тэргүүлэгч 10 орон, 2017,/сая ам.дол/

Улс	Хүн ам /сая /	ДНБ /тэрбум \$/	Хураамж , /сая \$/		Нийт хураамж /сая \$/	Амьдралын даатгал	
			Амьдралын даатгал	Амьдралын бус даатгал		Гүнзгий рэлт /%/	Нягтрал USD
АНУ	327	19,407.0	546,800	830,315	1,377,114	2.82	1674
НХАУ	1,410	1,856.0	317,570	223,876	541,446	2.68	225
Япон	127	4, 911.0	307,232	114,818	422,050	6.26	2411
Англи	66	2,628.0	189,833	93,498	283,331	7.22	3870
Франц	67	2,586.0	153,520	88,083	241,603	5.77	2222
Герман	83	3,691.0	96,973	126,005	222,978	2.63	1169
Ө.Солонгос	51	1,567.0	102,839	78,379	181,218	6.56	1999
Итали	61	1,941.0	113,947	41,562	155,509	6.20	1977
Канад	37	1,652.0	51,592	67,928	119,520	3.12	1407
Тайван	24	0,551.0	98,602	18,872	117,474	17.89	4195

Эх сурвалж: Swiss Re, sigma database, sigma 3/2018

Хүснэгт 2-оос харахад хөгжингүй орнуудад амьдралын даатгалын нийт даатгалын дүнд эзлэх хувийн жин өндөр байгаа бөгөөд Тайванд 83,9%, Итали 73,2%, Японд 72,7%, Англид 67%, Франц 63,5%, БНХАУ 58.6%, Өмнөд Солонгост 56,7%-ийг тус тус эзэлж байна. Япон, Итали улсын амьдралын даатгал нь амьдралын бусаасаа 2,7 дахин, Тайван 5,2 дахин их хураамжийн орлого төвлөрүүлсэн байна. Харин АНУ, Герман, Канад зэрэг орнуудад 39,7- 43,4 хувьтай байна. Харин амьдралын даатгалын гүнзгийрэлтийн түвшин, нягтралаас харахад хураамжийн орлого, ДНБ харьцаагаар Тайван, Англи, Өмнөд солонгос, Япон, Итали, Франц улсууд сайн байгаа бөгөөд нэг хүнд ногдох хураамжийн хэмжээгээр Тайван, Англи улсууд тэргүүлж байна. Даатгалын зах зээл хөгжсөн оронд хувь хүмүүс гэр бүл, үр хүүхдээ даатгуулахын зэрэгцээ ажил олгогч нь ажиллагсдаа амьдралын даатгалд хамт олноор нь хамруулж, тэдний нийгмийн хамгааллын асуудлыг цогцоор нь шийдвэрлэдэг бөгөөд төр засаг нь төрийн нуруунд үүрэх ачааг нь хөнгөлөлцөж өгсний төлөө иргэд, аж ахуйн нэгждээ татварын болон бусад урамшууллын бодлогоор дэмжлэг үзүүлдэг байна.

4. МОНГОЛ УЛСЫН АМЬДРАЛЫН ДААТГАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


Манай улсын хувьд “Улсын аюулаас хамгаалах газар” – ыг 1934 онд ЗСБНХУ – ын улсын даатгал (Госстрах) – ын газартай хамтран байгуулсан. 1990 онд Монгол даатгал компани арилжааны даатгал эрхлэх болсноор монголд хувийн хэвшил бүхий даатгалын зах зээл, даатгалын компаниуд үүсэх эхлэл болсон билээ. Монгол Улсын Засгийн газраас даатгалын зах зээлийн хөгжлийг дэмжих, нийгмийн амьдралд үзүүлэх үр нөлөөг нь өргөжүүлэх, амьдралын даатгалын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, даатгалын салбарын гол цөм болсон урт хугацааны амьдралын даатгалын тогтолцоог олон улсын жишгийн дагуу төлөвшүүлэн хөгжүүлэх чиглэлээр олон арга хэмжээг төрийн бодлогын баримт бичгүүдэд тусган шат дараатай авч хэрэгжүүлж байна. Монгол Улсын Их Хурал 1997 оны 12-р сарын 05-ны өдөр Даатгалын тухай Монгол улсын анхны хуулийг батлан гаргасан ба тус хуулийн шинэчилсэн найруулгыг 2004 оны 04-р сарын 30-ны өдөр батлан гаргаж, дагаж мөрдүүлснээр арилжааны даатгалын зах зээлийг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, санхүүгийн зах зээлд өөрийн гэсэн байр суурийг нэмэгдүүлж шинэ түвшинд үйл ажиллагаагаа эрхлэн явуулах таатай нөхцлийг бүрдүүлсэн юм. Санхүүгийн Зохицуулах Хороо нь амьдралын даатгалын үйл ажиллагааг зохицуулсан нийт 20 гаруй дүрэм, журам батлан мөрдүүлж байна. 2018 оны 3 дугаар улирлын байдлаар ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, давхар даатгалын 2 компани, тэдгээрийн 2421 төлөөлөгч, даатгалын зуучлагч 47, даатгалын хохирол үнэлэгч 27 компани даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж байна. 2018 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын салбарын нийт хөрөнгө 327.6 тэрбум төгрөгт 2017 оны үеийнхээс 102.8 тэрбум төгрөгөөр буюу 45.7 хувиар өссөн байна. Хүснэгт 3-ыг харна уу.

Хүснэгт 3. Даатгалын нийт хөрөнгө ,түүний өсөлт

Он	Нийт хөрөнгө / тэрбум ₮/	Өсөлт хувь	Амьдралын даатгал / тэрбум ₮/	Ердийн даатгал / тэрбум ₮/	Давхар даатгал / тэрбум ₮/
2016	201.4	18.0%	7.4	161.8	32.2
2017	224.8	12%	7.8	180.81	36.19
2018.09.30	327.6	45.7 %	8.6	249.9	69.1

Эх сурвалж: СЗХ санхүүгийн бюллетень ,2018,3

Салбарын хэмжээнд нийт хөрөнгөд эзлэх хувиар авч үзвэл ердийн даатгалын компаниудын хөрөнгө 76 хувь, давхар даатгалын компани 21 хувь, амьдралын даатгалын компани 3 хувийг тус тус эзэлж байна. Ердийн, амьдралын болон давхар даатгалын компаниудын хөрөнгө, салбарын нийт хөрөнгөд эзлэх хувийг зураг 1 - ээр харуулав.



Зураг 1. Нийт хөрөнгөд эзлэх хувь , Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, 2018,3

Даатгалын салбарын эдийн засаг, санхүүгийн зах зээлд эзлэх хувь хэмжээг тооцохдоо гүнзгийрэлтийн түвшин /penetration/-г голчилдог бөгөөд 2018 оны 3- р улирлын байдлаар амьдралын даатгалын хураамжийн орлогыг нэрлэсэн ДНБ-д харьцуулахад 0.0043 %-ийг эзэлж байна. Хүснэгт 4 - өөс харна уу.

Хүснэгт 4. Монгол улсын амьдралын даатгалын гүнзгийрэлтийн түвшин

Он	Хураамжийн орлого /сая ₮/	ДНБ /тэрбум ₮/	Гүнзгийрэлт
2016	1,268.6	23,940.0	0.0052 %
2017	1,306.3	27,900.0	0.0046%
2018.09.30	1,020.7	23,500.0	0.0043%

Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор (Санхүүгийн зохицуулах хороо, 2018,3)

Дээрх Монгол улсын амьдралын даатгалын гүнзгийрэлтийн түвшин олон улстай харьцуулж үзэхэд маш бага байна. Амьдралын даатгалын хэрэглээг тодорхойлох хүчин зүйлийн нэг нь нягтрал билээ. 2017 оны амьдралын даатгалын хураамжийн орлогыг хүн амын тоонд харьцуулахад манай улсын хувьд онд нэг хүнд 410.9₮ ногдож байна. Хүснэгт 5 - аас харна уу.

Хүснэгт 5. Монгол улсын амьдралын даатгалын нягтрал

Он	Хураамжийн орлого /сая ₮/	Хүн ам	Нягтрал /₮/
2016	1,268.6	3,119,935	406.6
2017	1,306.3	3,177,899	410.9

Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор (Санхүүгийн зохицуулах хороо, 2017)

"Нэйшнл Лайф Даатгал" ХХК нь 2008 онд урт хугацааны буюу амьдралын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий Монгол улсын анхны компани болж байгуулагджээ. "Нэйшнл Лайф Даатгал" ХХК компани нөхөн төлбөрийг шуурхай олгох, найдвартай байдлыг хангах үүднээс Германы Мюнхен Ре давхар даатгалын компанитай хамтран ажилладаг ба даатгуулагчдынхаа аялалын үеэрх аюулгүй байдлыг хангах үүднээс олон улсын яаралтай түргэн тусламжийн Интернэйшнл СОС байгууллагатай хамтран дэлхийн өнцөг булан бүрт даатгалын үйлчилгээгээ хүргэдэг. Тус компани анх 0.5 тэрбум төгрөгийн дүрмийн сантай, 0.2 тэрбум төгрөгийн алдагдлаас хамгаалах сантай байгуулагдсан бөгөөд хөрөнгийн хэмжээ жил бүр өссөн дүнтэй байна. Хүснэгт 6 -аас харна уу.

Хүснэгт 6. Амьдралын даатгалын компанийн нийт хөрөнгийн өсөлт

Он	2014	2015	2016	2017	2018.09
Нийт хөрөнгө /тэрбум ₮/	6.4	7.6	7.5	7.7	8.6

Эх сурвалж: СЗХ Даатгал санхүүгийн бюллетень


Хүснэгт 6 - аас харахад тус компани 2013 онд 6.4 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй байсан бол 2018 оны 3- р улирлын байдлаар 8.6 тэрбум төгрөг болж нийт хөрөнгийн хэмжээ 2.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Хураамжийн орлого, нөхөн төлбөр

Он	2014	2015	2016	2017	2018.09
Хураамж орлого /сая ₮/	1441.1	1652.8	1268.6	1306.3	1020.7
Нөхөн төлбөр /сая ₮/	635.41	943.89	886.02	905.52	456.5

Эх сурвалж: СЗХ Даатгал санхүүгийн бюллетень


Хүснэгт 7 - оос харахад хураамжийн орлого 2015 онд 14,6 хувиар өссөн хэдий ч 2016 оноос буурч, 2017 онд 2.9 хувиар өссөн байна. Энэ нь иргэдийн амьдралын даатгалын бүтээгдэхүүний сонирхох хандлагатай холбоотой. Даатгалын нөхөн төлбөр олголт хураамжтай уялдаатай өссөн байна. Зураг 2 - оос харна уу.



Зураг 2. Амьдралын даатгалын компанийн хураамж, нөхөн төлбөрийн харьцаа

Эх сурвалж: СЗХ Даатгал санхүүгийн бюллетень


Тус компани СЗХ-оос амьдралын даатгалын ерөнхий 4 төрлөөр тусгай зөвшөөрөл авч 20 гаруй төрлийн бүтээгдэхүүн зах зээлд гаргасан байна. Ерөнхий төрлүүдээр даатгалын хураамжийн орлогын бүтцийг 2018 оны 3 - р улирлын байдлаар зураг 3-д харуулав.



Зураг 3. Амьдралыг даатгалын хураамжийн орлогын бүтэц, /сая ₮/

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо 2018,3

Зураг 3-аас хураамжийн орлогын бүтцийг авч үзвэл нийт даатгалд эрүүл мэндийн даатгал 70,82 хувь, хугацаат даатгал 11,83 хувь, хуримтлалын даатгал 13,99 хувь, тэтгэврийн даатгал 3,36 хувийг тус тус эзэлж байна. Энэ нь иргэдэд олон улсын хэмжээнд үйлчилдэг эрүүл мэндийн даатгалын эрэлт их байгааг харуулж байна. Тэтгэврийн даатгалын хувь бага байгаа нь иргэд нийгмийн даатгалд албан журмын хураамж төлж даатгуулдагтай нэг талаар холбоотой боловч нөгөө талаар иргэд хувийн тэтгэврийн даатгалд даатгуулж хэвшээгүйтэй холбоотой байж болох юм.



Зураг 4. Амьдралыг даатгалын нөхөн төлбөрийн бүтэц, /сая ₮/

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо 2018,3

Зураг 4 - аас нөхөн төлбөрийн бүтцийг авч үзвэл нийт даатгалд эрүүл мэндийн даатгал 62.2 хувь, хугацаат даатгал 14.7 хувь, хуримтлалын даатгал 21.5 хувь, тэтгэврийн даатгал 1.6 хувийг тус тус эзэлж байна. Нөхөн төлбөрийн хувьд эрүүл мэндийн даатгалын нөхөн төлбөр хамгийн их, тэтгэврийн даатгалын нөхөн төлбөр хамгийн бага гарсан байна. Энэ нь тухайн даатгалын хураамжийн өсөлтөөс хамаарч байгаагаас гадна иргэдийн даатгалын үр шимийг хүртэх хугацаа нь эрүүл мэндийн даатгалын хувьд хурдан байдагтай холбоотой байж болох юм. Тус компанийн даатгалын нөөц сангийн хэмжээ даатгалын хураамжтай шууд хамааралтай өсч 2018 оны 3- р улирлын байдлаар 1.8 тэрбум төгрөгт хүрчээ. "Нэйшнл Лайф

Даатгал" ХХК компани 2008 – 2013 онд алдагдалтай ажиллаж, 2014 оноос ашигтай ажиллаж эхэлсэн байна. 2018 оны 3- р улирлын байдлаар 109.2 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

ДҮГНЭЛТ

1. Хөгжингүй орнуудад нийт даатгалын дүнд эзлэх амьдралын даатгалын хувийн жин өндөр байна
2. Монгол улсын амьдралын даатгалын гүнзгийрэлтийн түвшин, нягтрал олон улстай харьцуулж үзэхэд харьцангуй бага байна.
3. Амьдралын даатгал нь иргэд, айл өрхүүдийн хувьд амьдралын баталгаа болохын
4. зэрэгцээ санхүүгийн зах зээлийн хөгжилд ч томоохон хувь нэмэр оруулдаг боловч Монгол улсад хангалттай сайн хөгжөөгүй байна. Энэ нь манай улсад социализмын үеэс хэрэгжүүлж ирсэн даатгалын тогтолцоо, түүнээс улбаатай.
5. Иргэн, аж ахуйн нэгжүүд амьдралын даатгалын давуу талыг сайн ойлгуулах хэрэгтэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Балж. Г (2007) Эрсдэл ба даатгал, УБ
2. Батбаяр. Г (2002) Даатгалын менежмент, УБ
3. Мөнхзаяа. Б (2013) Санхүүгийн байгууллагын эрсдэлийн менежмент, УБ
4. Санхүүгийн зохицуулах хороо. (2017, 2018,3). Статистикийн бюллетень.
5. СЗХ (2012) Даатгалын нэр томъёоны тайлбар толь, УБ
6. Үндэсний статистикийн хороо. (2018 оны 09.30). Статистикийн нэгдсэн мэдээллийн сан.
7. Carter, R. (1992). *Success in Insurance*. United Kingdom: Hoder Education.
8. Swiss Re. (2018 оны 03). sigma 3/2018. Sigma database
9. <http://institute.swissre.com/research>
10. www.nco.mn
11. www.1212.mn
12. www.frc.mn